



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/291

Мөрөн сум

Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг
хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.17, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймаг дахь төрийн Аудитын байгууллагаас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 1 дүгээр, төсвийн гүйцэтгэлийн тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 дугаар, Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 дугаар, "Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл" нийцлийн аудитын тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Э.Аззаяа), Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Бэхбаяр), Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Базардамбуу), Санхүүгийн хяналт дотоод аудитын газрын дарга (А.Догсмоо), сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлж сум, байгууллагуудын 2025 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд гаргаж хэрэгжүүлэн, заасан хугацаанд тайлагнаж, өөрийн төсөвт хамаарах хугацаа хэтэрсэн өр, авлагыг барагдуулж ажиллахыг бүх шатны төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудад даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн засаг даргын 2025 оны 05
дугаар сарын 19 ний өдрийн 19 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭТГЭЭСЭН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага
1	Төсөвт газрууд болон орон нутгийн өмчит байгууллагууд нь санхүүгийн тайлангаа хуулийн цаглабарт хугацаанд санхүүгийн тайланг аудитын байгууллагад хүргүүлж, аудитад хамруулж байх	-Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд иж бүрэн тайлагнаж Төрийн аудитын байгууллагад хүргүүлэх	- Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс Орон нутгийн өмчийн газар
2	Авлага өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгах	-тооцоо нийлж өглөг авлага баталгаажуулах	- Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
3	Эд хөрөнгийн хариуцлагын гэрээний заалтыг тодорхой байгуулж, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах	- Хөрөнгийн бүртгэл, хадгалалт хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах	-Орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчийн газар
4	Хөдөө аж ахуйн корпарацаас олгогдсон пад тракторын тооцоог хийж төлбөр барагдаагүй байгаа иргэдийг шүүхэд шилжүүлэх	-Өр төлбөргүй болох	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
5	Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаар илэрсэн алдаа, зөрчлийг бууруулах, дахин гаргахгүй байхад анхаарч төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг Төрийн аудитын газар болон СТСХ-т хуулийн хугацаанд ирүүлэх.	-Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн Аудитын байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлэх.	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс

Аймгийн засаг даргын 2025 оны 05
дугаар сарын 19 ний өдрийн 2025 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИХ
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага
1	Төсвийг бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэл болон шинээр хэрэгжиж байгаа болон одоо мөрдөгдөж байгаа хууль журманд нийцүүлэн, хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөн саналаа ирүүлэх	-Орон нутгийн төсвийн төслийг холбогдох маягт, аргачлалын дагуу бэлтгэх, хянуулах, батлуулах	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
2	Улс, орон нутгийн төсөвт оруулах татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөж, нэр төрөл бүрээр бүрэн хангаж ажиллах Орон нутгийн төсвийн суурь орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн орлого нэмэгдүүлэх боломжийг бүрэн дайчилж төлөвлөн, нэр төрөл бүрээр гүйцэтгэлийг жигд ханган биелүүлж ажиллах	- Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т заасан чиг үүрийг хэрэгжүүлэхгүй байгаа төсвийн төвлөрүүлэн захирагч нарт хариуцлага тооцон ажиллах	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
3	ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын алдаа зөрлийг таслан зогсоох, төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх	-Удирдлагын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх -НББ-ийг сайжруулах	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
4	ТЕЗ-ийн хяналтад байдаг байгууллагуудын удирдлагуудын буруутай шийдвэр гаргаж албан хаагчдыг ажлаас халсантай холбоотой 202,5 сая төгрөгийн төрд учирсан хохирлыг бүрэн барагдуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллах	Өр төлбөрийг бүрэн барагдуулах тал дээр анхаарах	- Санхүү хяналт дотоод аудитын газар -Бүх шатны төсөв захирагчид	Санхүү хяналт дотоод аудитын газар
5	Халаалтын зардлыг нэмэгдсэн үнэ тарифаар санхүүжүүлэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийж, дулааны үнэ тарифыг бууруулах талаар эрчим хүчний зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллаж, өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээг авч ажиллах	- Төсвийн тухай хуулийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс

6	Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн /Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдэл болох Хөтөлбөр, төсвийн захирагч, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр тухайн оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл/ тайлагнаж байх	Энэ нь Төсвийн тухай хуулийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" заалттай нийцэхгүй байна	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс

Аймгийн засаг даргын 2025 оны 05
дугаар сарын 19-н өдрийн 729 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

УЛС ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНД
ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага
1	Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийн ашиглалтыг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх.	-Орон нутгийн өмчийн газар гаргасан тушаалдаа хэрэгжилт тооцож бүртгэдэг байх -Оны эцэст байгууллагуудтай тооцоо нийлж төрийн санд мэдээллээ бүрэн гаргаж хүргүүлдэг байх.	-Орон нутгийн өмчийн газар - Бүх шатны төсөв захирагчид	Орон нутгийн өмчийн газар
2	Зохиогч "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм"-д заасан шалгах хуудсыг ашиглан хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, зохиогчийн хяналтын санхүүжилт олгох шалгуур болгон ажиллах.	-Зохиогчийн хяналтын үр дүнд өгсөн зөвлөмжийг гүйцэтгэгч хэрэгжүүлж байгаа эсэхийг тухай бүр хяналтад авч, хэрэгжилтийг тооцож ажиллах.	-Барилга захиалагч хяналтын төв - Бүх шатны төсөв захирагчид	Худалдан авах ажиллагааны газар
3	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг шуурхай зохион байгуулж, хяналтыг хэрэгжүүлэх	-Орон нутгийн өмчийн газар гаргасан тушаалдаа хэрэгжилт тооцож бүртгэдэг байх -Оны эцэст байгууллагуудтай тооцоо нийлж төрийн сантай тулгаж байх	-Орон нутгийн өмчийн газар - Бүх шатны төсөв захирагчид	Бүс орон нутгийн хөгжлийн бодлого хөрөнгө оруулалтын хэлтэс
4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо бодит гүйцэтгэлийг pimis.publicinvestment.gov.mn цахим системээр хянаж байх.	pimis.publicinvestment.gov.mn цахим системийг бүрэн гүйцэт ашигладаг байх.	- Бүх шатны төсөв захирагчид	Бүс орон нутгийн хөгжлийн бодлого хөрөнгө оруулалтын хэлтэс
5	Захиалагчийн хяналтыг хууль, журамд заасан шаардлагын дагуу хянаж, гүйцэтгэлд нь анхаарал хандуулах, хариуцлагын тогтолцоог сайжруулах	-Хуулийн дагуу ажиллах.	-Барилга захиалагч хяналтын төв - Бүх шатны төсөв захирагчид	Худалдан авах ажиллагааны газар
6	Барилга байгууламжийн бетоны бат бэхэд тухай бүр лабораторийн шинжилгээ хийлгэсэн	- Чанар стандартын дагуу байгаа эсэхэд хяналт тавих	-Барилга захиалагч хяналтын төв	Барилга захиалагч хяналтын төв

	эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллах.		- Бүх шатны төсөв захирагчид	
7	Худалдан авах ажиллагааны үе шат бүрийн (техникийн тодорхойлолт боловсруулах, багцлах, эрх шилжүүлэх, үнэлгээний хороо байгуулах, тендер зарлах) уялдаа холбоог хангах нэгдсэн календарь төлөвлөгөө боловсруулж мөрдөх.	- Худалдан авах ажиллагааг чанартай үр дүнтэй зохион байгуулах.	- Худалдан авах ажиллагааны газар - Бүх шатны төсөв захирагчид	Худалдан авах ажиллагааны газар

Аймгийн засаг даргын 2025 оны 05
дугаар сарын 19 ний өдрийн 29 дугаар
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

**“ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ”
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага
1	Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-д заасан төрийн сангийн бие даасан тогтолцоог бий болгох зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх.	-Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-д заасан төрийн сангийн бие даасан тогтолцоог бий болгох зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх.	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
2	Төсөвт байгууллагуудын амлалт үүргийн бүртгэлд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах.	- Амлалт үүргийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөвт байгууллагуудын санхүүжилтийн эрхийг батлагдсан төлөвлөгөөний сарын хуваарийн дагуу олгож байх.	-Батлагдсан маягтаар төлөвлөгөөний дагуу хугацаанд нь санхүүжилтийг олгох	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
4	Төсвийн гүйцэтгэлийн авлага, өглөгийн мэдээг төсөвт байгууллагуудаас хүлээн авахдаа тамга гарын үсгээр баталгаажсан, эсэх болон өр, авлагыг үнэн зөв тусгасан эсэхэд хяналт тавьж хэвшүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.	- Өр төлбөрийг бүрэн барагдуулах тал дээр анхаарах	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
5	Төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогчдын гарын үсгийн баталгааг бүрэн гүйцэд гаргуулах, нягтлан бодогчдыг томилохдоо Сангийн яамны Санхүү төрийн сангийн хэлтэстэй зөвшилцсөн албан хаагчдыг томилуулж байхад хяналт тавьж ажиллах	Санхүүгийн ажилтныг томилохдоо “Сангийн сайдын 294”-р тогтоолыг мөрдөн ажиллах	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс

6	Санхүү, төрийн сангийн хяналтыг сайжруулан орлого бууруулах гүйлгээг таслан зогсоож, татан төвлөрүүлэлтийн дансанд зарцуулалтын эрх нээхгүй байх.	- 2024-12-31-ний Сангийн сайдын 254-р тоот тушаалыг мөрдөн ажиллах.	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
7	Санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хяналтын төлөвлөгөөнд туссан ажлуудын хэрэгжилт, үр дүнг тооцож, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах.	- 2024-12-31-ний Сангийн сайдын 254-р тоот тушаалыг мөрдөн ажиллах.	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
8	Төсвийн байгууллагуудын өдөр тутмын ажил гүйлгээнд тавих хяналтыг сайжруулж Зардлын элийн засгийн ангилал болон бусад хууль тогтоомж зөрчсөн гүйлгээг гаргахгүй байх тал дээр холбогдох арга хэмжээг авч ажиллах.	- 2025-06-02-ний Сангийн сайдын 112-р тоот тушаалыг мөрдөн ажиллах.	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
Бусад зүйл				
9	Сургалт зөвлөгөөний цахимаар зохион байгуулах, бэлэг дурсгалын зүйл худалдан авахгүй байх зэргээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өөрийн байгууллагын хэмнэх боломжтой зардлыг хэмнэх	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх	Бүх шатны төсвийн захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
10	Төсвийн орлогын бүрдүүлэлт, санхүүгийн эх үүсвэрийн боломжит нөхцөлтэй уялдуулан төсвийн байгууллага болон хөрөнгийг зардлыг эрэмбэлэн санхүүжүүлэх	Засгийн газрын тогтоол шийдвэрүүд	Бүх шатны төсвийн захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
11	2026 оны төсөвт анх батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа хэрэгжээгүй бол 2026 оны 05 дугаар сарын 31-нээс хойш хэмнэлтэд тооцох	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх	Бүх шатны төсвийн захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны газар